



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.10.04 № 05/8053.
танай 2018.08.27-ны № 01/3242 01/8053.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Татварын ерөнхий газрын харьяа Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Баянсангийн Даваасүрэн, Өмнөговь аймгийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Эрдэнэсайханы Билгүүн, тус аймгийн татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сугирын Жавхлан, Баян-Өлгий аймгийн татварын хэлтсийн татварын орлогын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Чеканы Бахытжан, Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Ганболор, Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн хувь хүний татварын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Доржбүрэгдаагийн Амаржаргал, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Шарбандийн Амаржаргал, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Ширэндэвийн Уянга, Налайх дүүргийн татварын хэлтсийн татварын орлогын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сандагийн Батцэцэг нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу тус албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллагын албан тушаалтанд гаргаж мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Хашбаатар
Х.ХАШБААТАР

0014372